

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот:

Удирдлага зохион байгуулалтын талаар:

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 138 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам батлах тухай 90 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын Засгийн газрын 01 албан даалгавар Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 273 дугаар тогтоол Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/43 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний 03 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын А/335 захирамж, “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” А/252 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/177 дугаар захирамж,уудын хэрэгжилтийг хангуулахаар байгууллагын даргын А тушаал 41, Б тушаал 12, гарган хэрэгжилтэнд хяналт тавьж, байгууллага аж ахуйн нэгжээс цахимаар болон албан бичгээр ирсэн нийт 134 албан бичиг хүлээн авч хариуг хугацаанд нь хүргүүлж, байгууллагын зүгээс 159 албан бичгийг боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай ” 14/01 дүгээр тогтоолтой нийцүүлж Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/720, 2015 оны А/471 захирамжуудыг шинэчлэхээр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/78 дугаар тушаалын дагуу ахмадын орон сууц хөтөлбөрт хамрагдах иргэдийг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулах ажлыг хэсгээс боловсруулсан журмын төсөлд саналаа тусгуулж батлуулахаар ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 сарын 20-ны өдрийн А/1090 дугаартай захирамжаар Сонгинхайрхан дүүргийн 19 хороо 21 хороололд нийслэлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд орсон 70 айлын орон сууцыг хүлээн авч эхний 51 айлаас 34 айлтай гэрээ байгуулж оршин суугчдын ая тухтай орчинд амьдрах арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны "Ахмадын хотхон-1" ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай А/230 дугаар тушаалын дагуу 1,2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг ОСНААУГазарт УДД-5 дугаар төвд инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны худгуудыг хүлээлгэн өгсөн.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт хүснэгтийн дагуу боловсруулж, байгууллагын дотоодод хийсэн хяналт шинжилгээний ажлын танилцуулга, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийн хамт 2018 оны 12 дугаар сарын 20-ны 156 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст, холбогдох мэргэжилтний цахим хаягаар тус тус хүргүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн e-doc програмын хэрэглэгчийн мэдээлэл нэвтрэх эрх, нууц үгийг холбогдох 5 ажилтанд эрх өгч ажилчид байгууллагад хамааралтай бичиг баримтуудыг шийдвэрлэнэ ажиллаж байна.

Оршин суугчдын гэрээ шинэчлэх ажлыг зохион байгуулж 901 дүгээр байрны 127 айл, 902 дугаар байрны 124 айл нийт 251 өрхтэй орон сууц түрээслэх гэрээг шинээр байгуулж, “Ахмадын орон сууцыг тусгай нөхцөлтэйгөөр хөлслүүлэх гэрээ”-ний сунгалтыг нийт 298 айл өрхтэй байгуулахаас одоогийн байдлаар 84,2 хувийн биелэлттэй байна.

Ахмадын орон сууцанд амьдарч буй иргэдийн хөдөлгөөний судалгааг сар бүрийн 25-ны дотор тус хотхоны оршин суугчдын хөдөлгөөний судалгааг нийслэлийн Захирагчийн ажлын албаны орон сууц хариуцсан мэргэжилтэн Э.Шийтэрийн d.shiiter@yahoo.com цахим хаягаар сар бүр хүргүүлж, 2018 онд нийт 22 айл өрхүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр нийслэлийн Захирагчийн ажлын албанд судалгааг нэгтгэн хүргүүлж 5 айл өрхийн асуудлыг шийдвэрлүүлж ажиллаа

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах Зөвлөлд 2017 оны тусгай зөвшөөрлийн гэрээний тайлан мэдээ, гэрээний биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт тус бүрээр гарган 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр хүргүүлж “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Хоёр.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу Эрчим хүчний Зохицуулах хорооноос гаргасан шийдвэр, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын өгсөн үүргийг хэрэгжүүлж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 06 сарын 06 -ны өдрийн "Ахмадын хотхон-1"ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай А/230 дугаар тушаалын дагуу ОСНААУГазарт УДДТөв, инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны худгуудыг хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны “Түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ тогтоох тухай” 26 дугаар тогтоолын дагуу хотхоны 901-р байрны 05 тоот өрөөнд “Эрхэс туяа” ХХК-тай 201702 дугаартай түрээсийн гэрээний дагуу “Эмийн сан”, 901-р байрны 06 тоот өрөөг “Төгс илэрхийлэл” ХХК-тай 201701 дугаартай түрээсийн гэрээний дагуу “Хүнсний дэлгүүр” ажиллуулах

түрээсийн гурвалсан гэрээнд сунгалт хийж 2018 оны 11 сарын байдлаар 8.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс ирүүлсэн 2018.01.23-ны өдрийн 04/244 дугаартай албан бичиг, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны даргын 2018.01.25-ны өдрийн 01/152 дугаар албан бичгийг тус тус хүлээн авч, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/43 дугаар захирамжийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд хангаж ажиллах 8 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулсан талаарх тайланг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтэст хүргүүлж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, биелэлтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж, мөн Нийслэлийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаварын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг улирал тутам гаргаж, сар бүрийн 05-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлагнаж ажилчдын сахилга хариуцлагыг өндөржүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Тэмцээн зохион байгуулах тухай” А/147 дугаар захирамжийн дагуу “АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГ-аас “Улаанбаатар Марафон”-д нэгдэцгээе уриан дор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомийг Хэсэгчилсэн инженерийн байгууламжийн хэлтсээс хүлээн авч, 2018 оны 04 дүгээр сарын 2-4-ны өдрүүдэд байгууллага дээр аялуулах хугацаанд ажилчдын дунд Сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, дартс зэрэг спортын төрлүүдээр уралдаан тэмцээн зохион байгуулж, Захирагчийн ажлын албанаас зохион байгуулах бооцоот тэмцээнд баг тамирчдыг оролцуулахаар 8 удаа спорт заал авч ажилчдыг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Зураг -1



“Улаанбаатар Марафон”-д тус байгууллагаас 10 километрийн зайд гараашийн жижүүр Н.Мөнхбатыг оролцуулахаар нэрийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир спортын газарт хүргүүлж, 2018 оны 05 дугаар сарын 19-ны өдөр “Улаанбаатар марафон-2018” олон улсын марафон тэмцээний 5 километрийн замд харуул хамгаалалтын ажилтан Н.Мөнхбат амжилтай оролцож батламж авсан. Зураг -2



Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамж, 2015 оны А/177 дугаар захирамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан биелэлтийг Нийслэлийн архивын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай тогтоолын дагуу Аюулгүй орчин-Иргэдийн оролцоо камержуулалт-2 болзолт уралдаанд хотхоны байруудыг камержуулсан тайлангаа хүргүүлж, Монгол улсын 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/918 дугаар захирамжийн хүрээнд байгууллагын дарга нар өөрийн хариуцсан хороонд ажилласан тайланг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажил гэсний хүрээнд захирамж гарсан өдрөөс хойш сар бүрийн 30-ны дотор хүргүүлэн ажиллаж байна.

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

Нийслэлийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэсэн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу илэрсэн дутагдал зөрчлийг арилгах, гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж төлөвлөгөөний биелэлт 85,2 хувьтай хэрэгжүүлж ажилласан.

Хотхоны цахилгаанчин, харуул, лифтчин, үйлчлэгч нарт өдөр тутмын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилга өгч ээлж хүлээлцүүлэлтэнд хяналт тавьж цахилгааны дуудлаганд хяналт тавьж, техник тоног төхөөрөмжтэй зөв харьцах аюулгүй ажиллагааны зааварчлага өгч хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангуулж зөрчил гаргалгүй ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/509 дүгээр захирамжийн хүрээнд Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид ажлын байранд төрийн албаны интернэт сүлжээгээр олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтууд (Facebook, Twitter, youtube, instagram) ашиглахгүй байх талаар арга хэмжээг холбогдох ажилтанууддаа авч ажилласан.

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/172 дугаартай Аян зохион байгуулах тухай тушаалын хүрээнд Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны Засаг даргын ажлын алба №05 тоот албан даалгаварыг гаргаж, 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 11 цагаас 13 цагийн хооронд “Шарилжгүй Улаанбаатар-3” аяны хүрээнд хотхоны байруудын нийтийн эзэмшлийн хог хаягдал, шарилжыг цэвэрлэх ажлын тайланг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны мэргэжилтэн Munkhbat1110@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 02/08 тоот албан даалгавар “Хөл газрын ургамал цэвэрлэх ажил зохион байгуулах тухай” 2018 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгууллагын гаднах орчны 50 метр хүртэлх зам талбайн шарилж, зэрлэг ургамлыг зулгаах, цэвэрлэх арга хэмжээний тайланг Засаг даргын Тамгын газарт болон хорооны Засаг даргын ажлын албанд urnaa_husle@yahoo.com хаягаар хүргүүлэн ажилласан. Хотхоны нийтийн эзэмшлийн байрны гадна талбайн шарилж өвсийг авч буй үеийн зураг (Зураг-3)



Хотын Ерөнхий Менежерийн 2018 оны А/01 тоот тушаалаар батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах хуваарийн дагуу 2018 оны 12 дугаар сарын 8-ний өдрийн 10:00 цагаас 13:00 цагийн хооронд Ахмадын хотхоны 901, 902, 813 байр болон шинээр хариуцан авсан Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21-р хороололд байрлах 63/1, 63/2 дугаар байруудын нийтийн эзэмшлийн гаднах хур хог хаягдлыг цэвэрлэх ажилд байгууллагын нийт 24 ажилчид бүх нийтийн цэвэрлэгээнд оролцож нийт 1000м² талбайн 2 тонн үүсмэл хогийн цэвэрлэсэн тайланг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны zaa_monitoring1@yahoo.com, monitoring@ub.service.mn цахим хаягаар хүргүүлэн ажиллаа. Хотхоны 901, 902 дугаар байрны 600м² талбайн ар тал болон урд тал, нийтийн эзэмшлийн үүссэн өнжмөл болон хур хог хаягдлыг цэвэрлэж байх үеийн зураг:

(Зураг-4)



Хотхоны 901, 902 дугаар байруудын талбайг цэвэрлэсний дараах үеийн зураг: (Зураг-5)



Хотхоны түр суурьшуулах 813 байрны 200^{м²} нийтийн эзэмшлийн талбай болох, хайс, хогийн бункар, цахилгаан щитний ойролцоох хуралдсан хог хаягдлыг цэвэрлэв. (Зураг-6)



Түр суурьшуулах 813 байрны гаднах орчныг цэвэрлэсний дараах үеийн зураг:

(Зураг-7)



Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо, 21-р хороололын 63/1, 63/2-р байруудын 200^{м²} нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлээ.

(Зураг-8)



Тус газар нь Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу Эрчим хүчний Зохицуулах хорооноос гаргасан шийдвэр, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын өгсөн үүргийг хэрэгжүүлж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 06 сарын 06 -ны өдрийн "Ахмадын хотхон-1" ОНӨААТҮГ-ын блансаас хөрөнгө шилжүүлэх тухай А/230 дугаар тушаалын дагуу ОСНААУГазарт УДДТөв, инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны худгуудыг хүлээлгэн өгсөнөөс хойш сантехникийн дуудлагаар үйлчилгээ хийхгүй байгаа болно.

Хотхоны 901,902 дугаар байруудад цахилгаан эрчим хүчтэй холбоотой-270, сантехникийн 350 дуудлага нийт 620 дуудлагыг тус тус хүлээн авч засвар үйлчилгээг түргэн шуурхай хийж иргэд оршин суугчдын тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж ажиллаа.

Хотхоны оршин суугчдын түрээсийн болон ашиглалтын төлбөрт нийт-**518,6** сая төгрөгийн орлого татан төвлөрүүлэхээс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар **383,3** сая төгрөгийг татан төвлөрүүлж, **432,2** бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулж, дагуу бүрдүүлж ажилласан. Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан болон холбогдох баримт материалыг нийслэл дэх Төрийн Аудитын газрын эрх олгосон “Далай ван” аудитын газарт хүргүүлж аудитын зөрчилгүй дүгнэлттэй ажиллаа.

“Ахмадын хотхон-1”ОНӨААТҮГ-ын 2018 онд хийгдэх засварын ажлын хуваарийг батлаж, батлагдсан хуваарийн дагуу 901, 902 дугаар байрны дээврийн ажил гүйцэтгэгчээр сонгогдсон “Ногоондом”ХХКомпанитай ХА/01 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан дээврийн засварын ажлыг 2018 оны 5 дугаар сарын 07-25-ны өдрүүдэд засварын ажлыг гүйцэтгүүлж борооны улирал эхлэхээс өмнө дээврийн засварыг хийж дуусгах ажлыг зохион байгууллаа.

-Хотхоны 901, 902 дугаар байруудын дээврийн засварын ажлыг “Ногоон-дом” ХХК-аар хийлгэхийн өмнөх үеийн зураг:

(зураг-9)



-Хотхоны 901, 902 дугаар байруудын дээврийн засварын ажлыг “Ногоон-дом” ХХК-аар хийлгэж байгаа үеийн зураг (зураг-10)




Хотхоны 901, 902 дугаар байруудын дээврийн засварын ажлыг “Ногоон-дом” ХХК-аар хийлгэсний дараах үеийн зураг: (зураг-11)



Хотхоны 901,902 дугаар байруудын дотор заслыг 2018 оны 06 сард тендер зарлаж тендерт “Би Эн Ти Жи” ХХК шалгарч засварын ажлыг хийж гүйцэтгэв. Засварын ажил 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэж 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авсан.

-Хотхоны 901, 902 дугаар байруудын дотор засварын ажлыг “Би Эн Ти Жи” ХХК-аар хийлгэхийн өмнөх үеийн зураг:


(зураг-12)




Хотхоны 901, 902 дугаар байруудыг дотор заслын дараах үеийн зураг :

2018 оны 9 дүгээр сарын 17-ноос хотхоны 901, 902 дугаар байрны гараашийн шал цутгах ажлыг өөрийн ажилтан албан хаагчид хийж гүйцэтгэллээ.

(Зураг-13)



(Зураг-14)



Хотхоны 901,902 дугаар байруудын гараашийн засварыг хийж автомашины зогсоолуудыг номерлож дугаарлав. Мөн халаалт авахтай холбогдуулан шат орц хонгил гараашийн шугам хоолойд үзлэг шалгалт хийж шаарлагатай хаалт арматурыг сольж халаалт авав.

Манай хороо-миний гудамж аяны хүрээнд Аюулгүй орчин-иргэдийн оролцоо “Камержуулалт-2” болзолт уралдааны удирдамжийн дагуу 901, 902 дугаар байранд оршин суугч иргэдтэй ярилцан санал авч өмнөх онд тавигдсан сондгой тоотой давхарын шатны эргэлтэн дээр тавигдсан камержуулалтыг нэмэгдүүлж гэмт хэрэг зөрчил гарч болзошгүй эрсдэл ихтэй давхаруудыг сонгон коридорт нь нийт 8 ширхэг дотор камер шинээр нэмж тавьсан.

(Зураг-15)



Хотхоны 901,902 дугаар байрны гадна хаалгыг домофон систем бүхий цоожтой хаалгаар сольж оршин суугчдад цахим түлхүүр /чип/-тэй болгох арга хэмжээ авч хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэнэмэл хүн орцонд хоноглохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

(Зураг -16)

Өмнөх хаалганы

Шинээр суурилуулсан хаалга



Түр суурьшуулах 813 дугаар байрны урд тал руу харсан цонхтой айлууд тагтнаасаа хог хаягдлаа шидэлж байгааг баримтжуулан хяналт тавих зорилгоор 1ш камерийг гэрлийн шон дээр шинээр суурилуулж Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж, иргэд оршин суугчдын ая тухтай орчинд амьдрах, болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.

(Зураг-17) Гадаа гэрлийн шон дээр байрлуулсан камер



-Ус дулаан дамжуулах төвүүдэд хийгдсэн засвар үйлчилгээ:

Ахмадын хотхоны 901, 902 дугаар байр түр оршин суух 813 дугаар байрны иргэд оршин суугчдын ая тухтай орчинд амьдрах нөхцлийг хангуулахаар Сар шинийн баяр, Улсын баяр наадам, Улс тунхагласаны байр, Шинэ жилийн баяр амралтын өдрүүдэд болон цочир хүйтрэлтийн үеүүдэд хариуцлагатай эргүүл жижүүр ажиллуулж, хэт ачаалал ихэдсэнээс шалтгаалж хэрэглээний халуун хүйтэн усны даралт унаж өндөр давхруудын айл өрхүүдэд ус очихгүй тасалдах нөхцөл үүсч болзошгүй тул зохих хэмжээгээр усаа нөөцлөж авах зөвлөгөөг хүргүүлж, 813 дугаар байрны халуун хүйтэн усны даралтын насосыг автомат удирдлагын тохиргоонд шилжүүлж, 902 дугаар байрны 133 тоотын хүйтэн усны буцах шугамын холболт, 94 тоотын халуун усны эргэлтийн буцах шугамд засвар хийж ажилласан. Тус хотхон нь 2017-2018 оны халаалтын улиралд дулааны эрчим хүчээр хангуулах №3501 дугаартай гэрээг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай байгуулж, 2017 оны 09 сарын 15-ны өдрөөс оршин суугчдад халаалтыг өгч 2017.09.15-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд оршин суугч иргэдээс нийт 141 дуудлага хүлээн авч ажилласанаас халаалттай холбоотой 46 дуудлага хүлээн авч ээлжийн слесариуд тухай бүр дуудлагын дагуу очиж айл өрхүүдийн халаалтын радиаторт үзлэг хийж, таслах хаалтыг нээн шугам хоолойн холбох хэрэгслүүдийг засварлах арга хэмжээ авч ажилласан.

Тус газраас явуулсан хүсэлтийн дагуу 2018 оны 7 дугаар сарын 17-нд зүүн түгээх төвийн Ерөнхий инженер Ц. Болорхүүгээр ахлуулсан ажлын хэсэгт ЦТП-95/2 901, 902 дугаар байрны УДДТөв, гадна шугам сүлжээг хүлээлгэн өгөв. 7-р сарын 31-ээс ОСНААУГазрын ХҮТ-5д 813 байрны УДДТөв, холигч насосны узель гадна шугам сүлжээ хүлээлцэх ажлыг эхэллээ. 8-р сарын 15нд ОСНААУГазарын зүүн түгээх төв, ХҮТ-5д 813, 901, 902-р байруудын УДДТ төвийн цахилгаан тоолуурын гэрчилгээ УСУГазар, Дулааны шугам сүлжээ ТӨХК-тай тооцоо нийлсэн акт холбогдох зураг халуун хүйтэн усны тоолуурын гэрчилгээ зэргийг хүлээлгэн өгөв. Мөн халаалт авахтай холбогдуулан шат орц хонгил гараашийн шугам хоолойд үзлэг шалгалт хийж шаарлагатай хаалт арматурыг сольж халаалт авав. Цахилгаан щитний өрөөнд автомат пускатель чангалгаа цэвэрлэгээ үйлчилгээ хийв.

-Байгууллагын цэвэр болон бохир усны худагт хийгдсэн засвар үйлчилгээ:

Бохир усны 26 худагт үзлэг шалгалтыг сар бүрийн 10, 25-нд тогтмол хийж цэвэрлэн, энэ улиралд 3,5,6,7,8,9 дүгээр худгууд бөглөрсөн байсныг гаргаж нийт 6 удаа ариутгах татуургын шугам хоолойн бөглөрлийг гаргаж хэвийн болгох арга хэмжээ авч ажилласан.

-Цахилгаан шатанд хийгдсэн засвар үйлчилгээ:

Түр суурьшуулах 813 дугаар байрны лифтийг хариуцан засвар үйлчилгээг хариуцдаг “Галт урсгал”ХХК-тай байгуулсан гэрээг цуцлаж, шинээр “Улаанбаатар лифт” ОНӨААТҮГ-т хариуцуулан өгч гэрээ байгуулж, гэрээний дагуу өргөх, буулгах моторын тосыг солиулж, эсрэг ачааны замуудын тосолгоо, техникийн үйлчилгээг тогтмол хийлгэж цахилгаан шатны хэвийн ажиллагааг бүрэн хангуулсан. Лифтэний өрөөнд үзлэг хийж реле солин 901, 902 дугаар байрны нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийг бүрэн болгож, түр суурьшуулах 813 дугаар байрны авто гараашийг ГХДБГазрын харуул хамгаалалтын дарга н.Ганбатат хүлээлгэн өгөв.

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Тус байгууллагын www.akhmadiinkhotkhon-1.ub.gov.mn цахим хуудсанд 2017-2020 хүртэлх байгууллагын стратеги төлөвлөгөө, 2016, 2017 оны үйл ажиллагааны жилийн тайлан мэдээ, 2018 оны хагас жил, жилийн тайлан, ажилчдын ажлын байрны тодорхойлолт, шилэн дансны мэдээлэл, орон сууцны ашиглалт үйлчилгээний талаарх шинээр батлагдсан үнэ тариф болон цаг үеийн бусад үйл ажиллагаатай холбоотой слайд мэдээг тухай бүр гарган байршуулж иргэд, оршин суугчдад байгууллагын үйл ажиллагааг нээлттэй мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн санхүүгийн ил тод байдлын талаарх мэдээллийг www.shilendans.gov.mn/main/agency/10289 линк хуудсыг хөтлөн ажиллаж байна.

Тав. Бусад мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан Хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлэх нь сэдэвт сургалтанд 1 ажилтан, Нийслэлийн Засаг даргын А/107 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудыг холбосон нэгдсэн UBSMART ERP цогц системийг хөгжүүлэх нэвтрүүлэхтэй холбогдуулан системийн сургагч багш бэлтгэх сургалтанд 2 ажилтан, Нийслэлийн Архивын газраас Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн ашиглалт, хэрэглээ сэдэвт сургалтанд Архив, бичиг хэргийн ажилтан хамрагдав. Нийслэлийн Засаг даргын А/252 захирамжийн дагуу хэрэгжиж буй Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн 3 дугаар хувилбарын хэрэглээ, ашиглалтыг сайжруулах нь сэдэвт сургалтанд 1 ажилтан, нийт 4 удаагийн сургалтанд ажилтнуудыг хамруулж мэдлэг боловсролыг нь дээшлүүлж ажиллаа.

“АХМАДЫН ХОТХОН-1” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР